



2025.08.30.

Улаанбаатар хот

ЭРЭЭНЦАВ ХК-ИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. Компанийн тухай ерөнхий мэдээлэл:

Эрэнцэв ХК (РД: 2011085; 1995 оноос өмнө Эрэнцэв САА) нь анх 1956 онд БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн тогтоолоор газар тариалан, мал аж ахуйн чиглэлээр байгуулагдсан. Оргил үедээ 32000 га газарт улаан буудай, малын тэжээл тариалдаг Монгол Улс даяар алдар нэр нь түгсэн томоохон аж ахуй байсан бөгөөд хожим 1995 онд хувьчлагдаж “Эрэнцэв” Хувьцаат компани болж, шинэчлэгдэн зохион байгуулагджээ. Үүнд:

- 1956.04.27-ны өдрийн БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 197-р тогтоол гарч Дорнод аймгийн Дашбалбар сумын нутагт байсан гянт болдын уурхайг түшиглэн нарийн ноост хонины аж ахуй байгуулах зорилгоор “Чулуунхороот”-ын САА байгуулагдан анхны галаа асаасан түүхтэй.
- 1959.11.15-нд газар тариалан, үр тарианы САА болгож одоогийн Чулуунхороот сумын нутаг болох Эрэнцэв, Бүс, Үүлэн ханы атар газрыг эзэмших зарлиг гарч, тухайн үеийн орон нутгийн нэрээр “Эрэнцэв”-ын САА гэж нэрлэн, одоогийн газар нутагт шилжиж ирсэн.
- 1969 оноос эхлэн “Эрэнцэв” САА нь Орос улсын байгалийн чанадаас сайн үүлдрийн нарийн ба нарийвтар ноосны хонь авч ирж, хонь үржүүлэх чиглэлийн мал аж ахуйг хавсарсан, үр тарианы чиглэлийн САА болон өргөжсөн.
- 1970 онд сум, САА-н төвд ЗХУ-ын хүч хөрөнгөөр орчин үеийн барилгууд барьж тохижуулсан.
- 1994 онд “Эрэнцэв”-ын САА татан буугдаж өмч хувьчлалаар хэд хэдэн аж ахуй нэгж болон задарч хөрөнгө нь хувьд шилжсэн.
- 1995.07.15-ний өдөр Монголын Хөрөнгийн биржид бүртгүүлэн “ЭРЭЭНЦАВ” Хувьцаат компани болсон.
- 2011.12.23-ний өдрийн Санхүүгийн зохицуулах хорооны 386-р тоот тогтоолоор “Эрэнцэв” ХК-ийн үнэт цаасны арилжааг дахин сэргээсэн ба хөрөнгийн зах зээлд нийт 99,720 ш хувьцааг гарган ажиллаж байна.

1.1. Компанийн эрх бүхий албан тушаалтан /Маягт-2/

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.7 /Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ТУЗ-н гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох бүрэн эрхтэй/-д заасны дагуу Эрэнцэв хувьцаат компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид өөрчлөгдөж, менежментийн шинэ баг ажиллах болсонтой холбогдуулан Б.Энхамгалан, Г.Отгонгэрэл, О.Тамир, М.Жалавдорж нарыг ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлж, бүрэн эрхийг дуусгавар болгох саналыг Хувьцаа эзэмшигчдийн 2023.03.09-ний өдрийн ээлжит хуралд оруулан шийдвэрлэлээ. Түүнчлэн тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр Мижиддоржийн Бат, Дашпунцагийн Эрдэнэзаяа, Зандаръяагийн Мөнхбат нарыг, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр Нэргүйн Баярсайханыг сонгосон байна.

1.2. ТУЗ-ийн бүрэлдэхүүн /Маягт-3/

	Овог, нэр	Регистрийн дугаар	Эзэмшдэг хувьцаа %	ТУЗ-н хараат / хараат бус гишүүн
1	Цэдэндамбын Лхагвадорж		-	ТУЗ-ийн дарга
2	Гэндэнгийн Одгэрэл		-	ТУЗ-ийн гишүүн
3	Мижиддоржийн Бат		-	ТУЗ-ийн гишүүн
4	Дашпунцагийн Эрдэнэзаяа		-	ТУЗ-ийн гишүүн
5	Лувсанзундуйн Ням		-	ТУЗ-ийн гишүүн
6	Зандаръяагийн Мөнхбат		12.16%	ТУЗ-ийн гишүүн
7	Лувсанзундуйн Даваа		-	Хараат бус гишүүн
8	Ожгоош Цацралтөр		-	Хараат бус гишүүн
9	Нэргүйн Баярсайхан		-	Хараат бус гишүүн

1.3. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид /Маягт-4/

Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч			Эрэнцэв ХК-ийн хувьцаа эзэмшилт		Бусад компаний хувьцааг эзэмшиж буй байдал		
	Овог нэр	Ажил, албан тушаал	Тоо ширхэг	Эзлэх хувь	Компаний нэр	Тоо ширхэг	Эзлэх хувь
1	Сийс гейт груп ХХК	ХХК	30,000ш	30.08%	-	-	-
2	Агро кор-Эл ХХК	ХХК	30,000ш	30.08%	-	-	-
3	Зандаръяа Мөнхбат	Иргэн	12,122 ш	12.16%	-	-	-
4	Дамба Энхжаргал	Иргэн	7,000 ш	7.02 %	-	-	-
5	Гэндэн Оюун	Иргэн	5,054 ш	5.07 %	-	-	-

1.4. Компанийн хөрөнгө, бүтэц, зохион байгуулалтын талаар

2025 оны хагас жилийн байдлаар Эрэнцэв ХК нь 321.1 сая төг-ийн өмчтэй болж өмнөх оны эцсээс 27.7 сая төг-өөр буурсан байна.


Өмчийн өөрчлөлтийн тайлан /КТХууль-96.4/

мян.төг

	Үзүүлэлт	Хувьцаат капитал	Хуримтлагдсан ашиг	Нийт эздийн өмч
1	2022.12.31-ны үлдэгдэл Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	181,600.00	210,483.95 (8,207.05)	392,083.95 (8,207.05)
2	2023.12.31-ны үлдэгдэл Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	181,600.00	167,243.45 (43,240.50)	348,843.45 (43,240.50)
3	2024.12.31-ны үлдэгдэл Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	181,600.00	167,243.45 (27,744.26)	348,843.45 (27,744.26)
4	2025.06.30-ны үлдэгдэл Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	181,600.00	167,243.45 (27,744.26)	348,843.45 (27,744.26)

Компанийн бүтэц, зохион байгуулалт /КТХууль-96.4.1/

Компанийн Бүтэц, зохион байгуулалтын схемийг ТУЗ-ийн 2023.01.25-ны өдрийн ТУЗ-08/2023 тоот тогтоолын 1-р хавсралтаар баталсан.



1.6. Эрх бүхий албан тушаалтанд олгосон шагнал урамшуулал, удирдлагын зардал

Компанийн тухай хуулийн 96-р зүйлийн 96.4.2-т “Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдэд зориулан жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаар бичиж хүргүүлэх бөгөөд тайланд компанийн эрх бүхий албан тушаалтанд олгосон шагнал урамшуулал, удирдлагын зардлын хэмжээг тусгана” гэж, Эрэнцав ХК-ийн “Компанийн засаглалын кодексийн тайлан”-ийн 24-т Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана гэж заасан. 2024 онд компанийн эрх бүхий албан тушаалтнуудад цалин, шагнал, урамшуулал олгоогүй байна.

2. Компанийн бизнесийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл

2025.02.10. ТУЗ-ийн хурал хуралдаж холбогдох асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Үүнд:

- Компанийн 2024 оны Үйл ажиллагааны тайланг хэлэлцэж батлах, дүгнэлт гаргах;
- Компанийн 2024 оны Санхүүгийн тайланг хэлэлцэж батлах, дүгнэлт гаргах;
- Компанийн 2024 оны Санхүүгийн тайланд аудит хийх байгууллагыг сонгох;
- Компанийн 2025 оны Үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;
- ТУЗ-ийн Байнгийн хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэх тухай;
- Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэр гаргах;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай шийдвэр гаргах;

зэрэг асуудлуудыг хэлэлцээд асуудал тус бүрээр ТУЗ-ийн тогтоолууд гаргасан. Үүнд:

1. 2024 оны тайлангийн жилд Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй;
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025.04.25-ны өдөр зарлан хуралдуулах;

2025.01.10. Компанийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх гэрээг Ай Жей Эй Эйч ХХК-тай байгуулж, санхүүгийн тайланд үнэлэлт дүгнэлт гаргуулан, Сангийн яам, Татварын ерөнхий газруудад тайлагнан ажиллалаа.

2024.03.20. Компанийн нийт Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулж холбогдох шийдвэрүүдийг гаргалаа. Үүнд:

- Компанийн 2023 оны Үйл ажиллагааны тайлангийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
- Компанийн 2023 оны Санхүүгийн тайлангийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
- ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
- 2024.01.11. Компанийн тухай хуульд заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай шийдвэр болоод бусад холбогдох баримт, бичгүүдийг 2024.01.11-ний өдрийн 05/01 тоот албан бичгээр Санхүүгийн зохицуулах хороо болоод Хөрөнгийн биржид хүргүүлсэн.

- 2024.03.22. Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурлаас гаргасан шийдвэрүүд болоод хурлын тэмдэглэлийг Компанийн тухай хуулийн дагуу Санхүүгийн зохицуулах хороо болоод Хөрөнгийн биржид хүргүүлсэн.
 - 2024.04.12. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт албан тоот хүргүүлж компанийн эзэмшлийн газар тариалангийн 39 нэгж талбар, үйлдвэрлэл үйлчилгээний 2 нэгж талбарын лавлагааг Газрын мэдээллийн нэгдсэн сангаас гаргуулж авсан.
 - 2024.04.16. Дорнод аймгийн Чулуунхороот суманд байрлах тариалангийн газраас хөрсний дээж авч Инженер геодези ХХК-ийн лабораторид Хөрсний агрохимийн шинжилгээ хийлгэн дүгнэлт гаргуулж авсан.
 - 2024.05.10. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын **egazar.gov.mn** цахим системд хүсэлт илгээж компанийн эзэмшлийн нэгж талбаруудын Улсын бүртгэлийн дугаар, Газар эзэмших шинэчилсэн гэрчилгээнүүдийг Улсын бүртгэлийн ерөнхий газраас гаргуулан авсан.
 - 2024.06.17. Дорнод аймгийн Чулуунхороот сумын засаг даргад 14/01 тоот албан бичгийг хүргүүлж, компанийн эзэмшлийн нэгж талбаруудын эзэмшлийн гэрээний хэрэгжилтийг дүгнэж, Гэрээ дүгнэсэн актуудыг албажуулан авсан.
 - 2024.06.27. Санхүүгийн зохицуулах хорооны Компанийн засаглалын кодекс, Монголын хөрөнгийн биржийн Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг үнэлэх аргачлал, Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам зэрэгт заасны дагуу Эрээнцав ХК-ийн “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн тайлан, үнэлгээ”, “Байгаль орчин, нийгэм, засаглал, тогтвортой байдлын тайлан” зэргийг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн.
- 2023.03.12. Компанийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, гадаад харилцааг өргөжүүлэх зорилгоор -ны өдрүүдэд БНХАУ-ын Хөх хотод зохион байгуулагдсан Хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн хангамжийн үзэсгэлэн яармагт компанийн ТУЗ-н дарга Ц.Лхагвадорж, Гүйцэтгэх захирал М.Бат нар оролцсон. Уг арга хэмжээний үеэр Эрээнцав компанитай хамтран ажиллах, хөрөнгө оруулах сонирхолтой компани, хувь хүмүүстэй албан уулзалтууд зохион байгуулж, газар тариалан, мал аж ахуйн чиглэлд тодорхой ажлууд хийхээр тохирсон болно.
- 2023.04.16. БНХАУ-ын Жиангсу мужийн Jiangsu Great Food компанитай хөдөө аж ахуйн чиглэлээр хамтран ажиллах Санамж бичгийг байгуулан, гарын үсэг зурж баталгаажуулсан.
 - 2023.08.04. Махны үйлдвэрлэлийн чиглэлээр ажиллах FEST Development ХХК-ийг Эрээнцав ХК-ийн оролцоотой байгуулсан.

Түүнчлэн, Эрээнцав ХК-ийн хувьд 2019-2022 онуудад дэлхий нийтийг хамарсан цар тахал, улс орны эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан компанийн үйл ажиллагаа удааширч саарсан хэдий ч, тулгарсан хүндрэл бэрхшээлийг даван туулж, 2023 онд компанийн засаглалын болоод эрсдэлийн удирдлага, дотоод хяналтыг сайжруулах зорилгоор тодорхой шинэчлэлт, өөрчлөлтүүдийг хийгээд ажиллаж байна.

- Компанийн тухай хуулийн 81-р зүйлийн 81.2-т заасны дагуу 2022.10.15-ны өдрийн ТУЗ-н хурлын 04-р тогтоолоор ТУЗ-н дэргэдэх Аудитын, Цалин, урамшууллын, Нэр дэвшүүлэх хороодыг байгуулж хороодын гишүүдийн 2/3-ыг хараат бус гишүүдээс бүрдүүлсэн.
- 2022.11.11-ний өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 06-р тогтоолоор ТУЗ-н дэргэд ажиллах Эрсдэлийн удирдлагын хороог байгуулж, хорооны гишүүдийн 2/3-ыг хараат бус гишүүдээр бүрдүүлээд байна.
- Компанийн засаглалын кодексийн зарчмуудыг мөрдлөг болгох үүднээс тус компанийн засаглалын тогтолцоонд тулгарч буй асуудлуудыг тодорхойлох, түүнд үндэслэн заавар, зөвлөмжийг боловсруулан мөрдүүлэх нь компанийн засаглалын түвшинг сайжруулна гэж үзээд үйл ажиллагаандаа дараах үндсэн зарчмуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

1. ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах;
2. ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүргийг нарийвчлан тодорхойлох;
3. Тайлагнал, мэдээллийн ил тод, байдлыг хэвшүүлэх;
4. Аудит, хяналтын тогтолцоог үр дүнтэй ашиглах;
5. Эрсдэлийн удирдлагыг үр дүнтэй хэрэгжүүлэх;
6. Эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллыг журмын дагуу тогтоох;
7. Оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн үзэж, хамгаалах;
8. Компанийн соёлыг бий болгох, хэвшүүлэх;
9. Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах;

зэрэг болно.

- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022.11.11-ний өдрийн хурлын 05-р тогтоолоор дараах Дүрэм, Журам, Бодлогын баримт бичгүүдийг хэлэлцэн батлаад, хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Компанийн ТУЗ-н үйл ажиллагааны журам;
2. Компанийн ТУЗ-ын Хороодын үйл ажиллагааны журам;
3. Аудитын хорооны үйл ажиллагааны журам;
4. Цалин, урамшууллын хорооны үйл ажиллагааны журам;
5. Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журам;
6. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам;
7. Компанийн ёс зүйн дүрэм;
8. Нэгдмэл сонирхолтой этгээдийн болон сонирхолын зөрчилтэй хэлцлийн талаар баримтлах бодлого;
9. Компанийн Залгамж халааны бодлогын баримт бичиг;
10. Аудитын бодлогын баримт бичиг;
11. Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам;
12. Дотоод хяналтын журам;
13. Санхүүгийн үйл ажиллагааны журам;
14. Ногдол ашгийн журам;
15. Мэдээллийн үйл ажиллагааны журам;
16. Комплайнсын хяналтн заавар;
17. Оролцогч талуудтай харилцах Бодлогын баримт бичиг;

зэрэг болно.

- Эрэнцав ХК-ийн ТУЗ нь “Компанийн засаглалын кодекс”-ийн биелэлт, хэрэгжилтэнд хяналт тавин ажилладаг бөгөөд компанийн засаглалын зарчмуудын бүхий л заалтуудыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжүүлэн ажиллахын сацуу Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ын хурлуудаар батлагдсан компанийн засаглалын удирдлагын баримт бичгүүдийг Хөрөнгийн биржийн цахим хуудас болоод Эрэнцав ХК-ийн цахим хуудсанд нээлттэй, ил тод байршуулан олон нийтэд хүргэж, мэдээлэн ажиллаж байна. Компанийн засаглалын кодексийн тайлангийн 14-т “Үйл ажиллагааны тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна” гэж, 26-д “Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2022.11.18. Эрэнцав ХК-ийн нийт хувьцааны 30.08 % буюу 30,000 ш хувьцааг Сийс гейт груп ХХК худалдан авсан.

2022.11.29. Эрэнцав ХК-ийн нийт хувьцааны 30.08 % буюу 30,000 ш хувьцааг Агро кор-эл ХХК худалдан авсан.

2022.12.08. Эрэнцав ХК-ийн нийт хувьцааны 12.16 % буюу 12,122 ш хувьцааг иргэн З.Мөнхбат худалдан авсан.

- 2023.04.12. Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны бүртгэлийн журмын 10.7-д заасны дагуу Эрэнцав ХК-ийн 2023 оны 1-р улирлын үйл ажиллагааны тайланг 030/01 тоот албан бичгээр хүргүүлсэн.

2023.04.27. Санхүүгийн зохицуулах хорооны Компанийн засаглалын кодекс, Монголын хөрөнгийн биржийн Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг үнэлэх аргачлал, Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам зэрэгт заасны дагуу Эрэнцав ХК-ийн “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн тайлан, үнэлгээ”, “Байгаль орчин, нийгэм, засаглал, тогтвортой байдлын тайлан”, “Эрх бүхий албан тушаалтан болон бусад боловсон хүчний тодорхойлолт” зэргийг хүргүүлсэн.

2023.11.21. Улсын бүртгэлийн газарт 096/01-р албан тоотыг хүргүүлж, Дорнод аймгийн Чулуунхороот суманд байрлах Эрэнцав ХК-ийн эзэмшлийн Y0613000050, Y0613000074 тоот улсын дугаартай үл хөдлөх хөрөнгүүдийг бүртгүүлсэн.

2023.12.05. Дорнод аймгийн татварын албанд 098/01-р албан тоотыг хүргүүлж Y0613000050, Y0613000074 тоот улсын дугаартай үл хөдлөх хөрөнгүүдийг бүртгүүлсэн.

2023.11.22. Дорнод аймгийн Татварын хэлтсийн даргын 7231103588 тоот шийдвэрийн дагуу компанийн 2019.01.01-2021.12.31-нийг хамрах хугацааны үйл ажиллагаанд Татварын хяналт шалгалт хийсэн.

2023.01.16. Монгол Улсын Газрын тухай хуулийн 53-р зүйлд заасны дагуу Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажил гүйцэтгэх гэрээг Хөдрөг цэцүүх ТМЗ ХХК-тай байгуулж, компанийн эзэмшлийн газар тариалангийн болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай 10,000 га газрын төлөв байдал, чанарын баталгааг үнэлэн албажуулж, ГЗБГЗГазарт тайлагнан ажиллалаа.

2024.06.30. Татварын тухай болон Газрын тухай хуулиудын хүрээнд 2024 оны Газрын татварт эхний хагас жилийн байдлаар 6.1 сая төгрөгийг төлөөд байна.

3. Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл

Эрэнцав ХК-ийн нийт 99.720 /ерэн есөн мянга долоон зуун хорин/ ширхэг хувьцааны 84.41%-ийг Сийс гейт ХХК, Агро кор-Эл ХХК, З.Мөнхбат, Д.Энхжаргал, Г.Оюун нар эзэмшдэг. Үлдсэн 15.59%-ийг бусад хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна.

4. Ногдол ашгийн талаарх мэдээлэл

2024 онд Эрэнцав ХК-ийн бизнесийн үйл ажиллагаа тогтворгүй байсан тул ашиг, орлого ороогүй. Иймээс ТУЗ-ийн 2025.02.10-ны өдрийн ТУЗ-02/2025 тоот тогтоолоор ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн.

5. Санхүүгийн байдлын талаарх мэдээлэл

2024 онд компанийн санхүүгийн үйл ажиллагаанд өөрчлөлт ороогүй байна.

6. Бусад шаардлагатай мэдээлэл

Нэмэлт мэдээлэл байхгүй.

7. Үйл ажиллагааны өөрчлөлт, шилжилт /Маягт-9/

2025 онд үйл ажиллагаанд өөрчлөлт ороогүй болно.

8. Үйл ажиллагаандаа шинэ техник, технологи нэвтрүүлсэн байдал /Маягт-10/

Үйл ажиллагаанд шинэ техник, технологи нэвтрүүлээгүй байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:

